



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2023/10-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас:7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
	Аудитор: Б.Наранцэцэг
	Утас: 7036-2442 Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-18
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18-20
4. Аудитын тайлан	21-20
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. Аудитын илрүүлэлт	23-24
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	24-28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хүн амын орлогын албан татвар
ЗДНХ	Засаг Даргын нөөц хөрөнгө



САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.ШИЖИРБААТАР ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.25 № САА 2023/10-НАСТАТЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сант сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 75.6 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 24.4 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Сант сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 33.9 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 25.1 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 27.3 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байгаа бөгөөд цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 348,929.2 мянган төгрөг, байр ашиглалттай

018020363₃

холбоотой тогтмол зардалд 258,801.4 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 280,999.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	645,095.20	467,393.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	329,394.00	375,135.70
33	АВЛАГА	135,882.40	76,223.20
35	БАРАА МАТЕРИАЛ	179,818.90	16,034.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,208,516.60	2,142,548.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,208,516.60	2,142,548.20
39100	Газар	0.00	532,632.80
39200	Биет хөрөнгө	5,059,164.50	1,533,406.20
39300	Биет бус хөрөнгө	149,352.10	76,509.20
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,853,611.80	2,609,941.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,553.40	168.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,553.40	168.00
41300	Өглөг	12,553.40	168.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,841,058.40	2,609,773.80
51	Засгийн газрын хувь оролцоо	5,841,058.40	2,609,773.80
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,386,441.90	627,122.10
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,386,441.90	627,122.10
51200	Хуримтлагдсан үр дүн	219,493.50	1,630,084.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,235,123.00	352,566.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,853,611.80	2,609,941.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,701,806.40	2,005,187.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО	150,778.60	255,259.50
110	Орлогын албан татвар	36,747.40	135,081.10
1100	Хувь хүний орлогын албан татвар	36,747.40	135,081.10
113	Хөрөнгийн албан татвар	86,572.00	59,619.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,459.10	60,558.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	243,435.40	843,880.70
120	Нийтлэг татварын бус орлого	243,435.40	843,880.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,307,592.50	906,046.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,440,502.70	872,504.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,440,502.70	862,404.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,298,528.00	843,275.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,285,685.20	312,205.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,923.50	38,459.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,277.00	258,801.40
2104	Хангамж, бараа материалын зардал	70,568.20	37,022.40
2105	Нормативт зардал	147,027.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,698.40	15,676.10
2107	Томилолт, зочны зардал	2,502.20	4,965.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,155.20	14,844.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	385,391.20	161,300.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142,274.70	19,128.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	10,100.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	261,303.80	1,132,682.60
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	137,540.80	4,362,447.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	123,762.90	-3,229,764.50

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,543,223.60	1,246,790.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО	150,778.60	255,259.50
110	Орлогын албан татвар	36,747.40	135,081.10
1100	Хувь хүний орлогын албан татвар	36,747.40	135,081.10
113	Хөрөнгийн албан татвар	86,572.00	59,619.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,459.10	60,558.90
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,372.20	3,474.00
1181	Газрын төлбөр	1,675.40	37,141.90
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	21,411.50	19,943.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	97,744.80	85,484.30
120	Нийтлэг татварын бус орлого	97,744.80	85,484.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,294,700.20	906,046.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,160,473.50	816,689.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,160,473.50	816,689.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,015,899.40	797,560.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,283,775.20	312,205.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	167,822.20	38,459.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,277.00	258,801.40
2104	Хангамж, бараа материалын зардал	64,302.80	36,392.40
2105	Нормативт зардал	155,807.20	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,915.10	29,333.80
2107	Томилолт, зочны зардал	2,502.20	4,965.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,858.90	14,844.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,638.80	102,558.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144,574.10	19,128.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	382,750.10	430,101.20
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	148,269.80	384,359.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	148,269.80	384,359.50
2200	Дотоод эх үүсвэрээр	148,269.80	384,359.50
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-148,269.80	-384,359.50
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	234,480.30	45,741.70
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	94,913.60	329,394.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	329,394.00	375,135.70

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,717,295.50	5,717,295.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,717,295.50	5,717,295.50
4	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00
7	Тайлант үеийн үр дүн	123,762.90	123,762.90
8	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,841,058.40	5,841,058.40
9	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,841,058.40	5,841,058.40
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-331,489.80	-331,489.80
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,509,568.70	5,509,568.70
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00
13	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00
15	Тайлант үеийн үр дүн	-3,229,764.50	-3,229,764.50
16	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,609,773.80	2,609,773.80

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,361,181.10	1,028,702.84	332,478.26	75.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	825,968.50	747,703.32	78,265.18	90.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	805,672.00	728,574.42	77,097.58	90.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	337,669.60	310,469.37	27,200.23	91.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,231.00	38,459.80	3,771.20	91.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	291,043.80	258,801.35	32,242.45	88.92
2104	Хангамж, бараа материалын зардал	40,576.30	33,324.81	7,251.49	82.13
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,661.20	29,333.76	2,327.44	92.65
2107	Томилолт, зочны зардал	5,275.00	4,965.00	310.00	94.12
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,809.00	14,844.70	964.30	93.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,406.10	38,375.63	3,030.47	92.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,296.50	19,128.90	1,167.60	94.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,296.50	19,128.90	1,167.60	94.25
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	334,389.10	280,999.52	53,389.58	84.03
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200,823.50	0.0	200,823.50	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,361,181.10	1,101,598.53	259,582.57	80.93
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,141,871.00	1,054,837.12	87,033.88	92.38
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	219,310.10	46,761.41	172,548.69	21.32
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	104,476.10	0	0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	177,371.79	0	0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	50	50	0.0	100
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0.0	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	23	23	0.0	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	191,164.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	87,804.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,986.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,736.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,067.61
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,182.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,818.58
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,818.58
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	103,360.00
2251	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	103,360.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	191,164.75
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	191,164.75
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Сант сумын ТТЗ гэх/-ийн 2022 оны үйл ажиллагааны зорилгыг “Бүтээн байгуулалт-Нийгмийн хөгжлийг дэмжих жил” гэж тодорхойлсон байна.

Дээрх дэвшүүлсэн зорилт арга хэмжээний хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- ✓ Төрийн ажил үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг хангах,
- ✓ Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх,
- ✓ Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, иргэдийн оролцоог хангаж хамтран ажиллах,
- ✓ Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- ✓ Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- ✓ Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- ✓ Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- ✓ Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- ✓ Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- ✓ Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2022 оны 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”-д өөрчлөлт оруулсан,
- Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлөгдөх, хяналт тавих журамд ХХААХҮ-ийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 26-ны А/243 тушаалаар журамд нэмэлт өөрчлөлт оруулсан гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагдах төсөвт байгууллагуудын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,243,670.1 мянган төгрөгөөр буюу 44.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	329,393.9	375,135.7	45,741.8
Авлага	135,882.4	76,223.2	(59,659.2)
Бараа материал	179,818.9	16,034.7	(163,784.2)
Үндсэн хөрөнгө	5,208,516.6	2,142,548.1	(3,065,968.5)
Нийт хөрөнгө	5,853,611.8	2,609,941.8	(3,243,670.1)
Өр төлбөр	12,553.4	168.0	(12,385.4)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,841,058.4	2,609,773.7	(3,231,284.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,853,611.8	2,609,941.8	(3,243,670.1)

Дээрх хүснэгтээс харахад, нийт хөрөнгийн үлдэгдэл 2,609,941.8 мянган төгрөг болж, 3,243,670.1 мянган төгрөгөөр буурсан нь бүтцийн өөрчлөлтөөр ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэгийн 4,553,604.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 163,164.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 329,393.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 375,135.7 мянган төгрөг болж, 45,741.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	329,393.9	375,135.7	45,741.8
Дүн	329,393.9	375,135.7	45,741.8

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан ОНЕО-ын дансанд 197,763.9 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 42,303.2 мянган төгрөг, ХХС-ийн дансанд 135,068.6 мянган төгрөг зэрэг нийт 375,135.7 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 135,882.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 76,223.2 мянган төгрөг болж, 59,659.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татаас санхүүжилтийн авлага	12,385.4	0.00	(12,385.4)
Байгууллагаас авах авлага	1,270.7	1,270.7	0.00
Хувь хүмүүсээс авах авлага	6,980.7	6,085.6	(895.0)
Хувь хүмүүст олгосон зээл	102,435.7	63,251.2	(39,184.5)
Зээлийн хүүгийн авлага	12,810.0	5,615.7	(7,194.3)
Дүн	135,882.4	76,223.2	(59,659.2)

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- ЗДТГ-ын байгууллагаас авах авлагын дансанд “Гавшгай ус” ОНӨААТҮГ-аас авах усны төлбөрийн 1,270.7 мянган төгрөгийн,
- ОНӨО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 6,085.6 мянган төгрөгийн /авлагыг барагдуулахаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлд шилжүүлэн эвлэрүүлэн зуучлалын журмаар маргаанаа шийдвэрлэхээр тогтсон байна/,
- Зээлийн 63,251.2 мянган төгрөг, зээлийн хүүгийн 5,615.7 мянган төгрөг зэрэг нийт 68,866.9 мянган төгрөгийн ХХС-тай холбоотой авлагууд тус тус тайлагнагдсан байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 179,818.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 16,034.7 мянган төгрөг болж, 163,784.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	22,550.8	0.00	(22,550.8)
Эм боох материал	29,461.3	0.00	(29,461.3)
Бичиг хэргийн материал	899.0	40.0	(859.0)
Аж ахуйн материал	15,781.6	13,612.4	(2,169.2)
Барилгын засварын материал	3,643.3	0.00	(3,643.3)
Хүнсний материал	11,103.4	0.00	(11,103.4)
Бусад хангамжийн материал	96,379.5	2,382.3	(93,997.2)
Дүн	179,818.9	16,034.7	(163,784.2)

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Материалын дансны үлдэгдэл 163,784.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 58,580.1 мянган төгрөгийн бараа материал

худалдан авч, 59,199.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан болон бүтцийн өөрчлөлөөр ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэгийн нийт 163,464.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Сант сумын ТТЗ-ийн харьяаны дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна. Үүнд:

- ЗДТГ нь 9,327.6 мянган төгрөг,
- ИТХ нь 9,544.8 мянган төгрөг.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 6,348,438.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,721,323.9 мянган төгрөг болж, 3,627,114.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	4,941,735.2	463,258.2	(5,404,993.4)
Авто-тээврийн хэрэгсэл	212,555.4	223,252.9	10,697.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	433,867.5	102,173.4	(331,694.1)
Тавилга, аж ахуйн эд хогшил	171,974.8	28,650.5	(143,324.2)
Бусад үндсэн хөрөнгө	356,427.2	1,212,000.5	855,573.3
Дуусаагүй барилга байгууламж	46,116.6	86,080.3	(39,963.7)
Программ хангамж	8,229.0	5,479.0	(2,750.0)
Бусад биет бус хөрөнгө	144,478.8	606,582.0	462,103.2
Ном	33,054.3	0.00	(33,054.3)
Дүн	6,348,438.7	2,721,323.9	(3,627,114.8)

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,627,114.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 13,657.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 532,632.8 мянган төгрөгийн газрыг үнэ төлбөргүйгээр, аймаг, сумын ОНХС-ийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 380,199.5 мянган төгрөгийн гүний худаг, гудамжны гэрэлтүүлэг, зам засвар, тоглоомын талбай зэргийг шилжүүлэн авч, бүтцийн өөрчлөлтөөр ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэгийн нийт 4,553,604.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн тайланд ашиглалтад хүлээн авсан 46,116.0 мянган төгрөгийн ахмадын байрыг дуусаагүй барилгад тайлагнасан байна.
- ЗДТГ нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 26 нэр төрлийн хөрөнгийн үлдэх өртгийг 12,897.7 мянган төгрөгөөр хасах дүнгээр илэрхийлж, үлдэх өртгийн дүнг бууруулсан байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 12,553.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 168.0 мянган төгрөг болж 12,385.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	2,013.9	168.0	(1,845.9)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	10,539.5	0.0	(10,539.5)
Дүн	12,553.4	168.0	(12,385.4)

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Өр төлбөрийн үлдэгдэлд ИТХ-ын цалингийн 168.0 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

• ИТХ-ын өр төлбөр дансанд тайлагнагдсан 168.0 мянган төгрөгийн цалингийн өглөг нь тооцоо нийлсэн актгүй, эзэн холбогдогч нь тодорхой бус байгаагаас барагдаагүй байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,841,058.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,609,773.8 мянган төгрөг болж, 3,231,284.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,386,441.9	627,122.1	(1,759,319.8)
Хуримтлагдсан үр дүн	219,493.5	1,630,084.9	1,410,591.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,235,123.0	352,566.8	(2,882,556.2)
Дүн	5,841,058.4	2,609,773.8	(3,231,284.6)

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэг зэрэг байгууллагууд нь санхүүгийн хаалтын тайлан гаргаж, засгийн газрын санг бууруулан бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.7 Орлогын данс

Орон нутгийн төсөвт 288,442.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөн баталж, гүйцэтгэлээр 293,982.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 101.9 хувиар биелүүлсэн байна.

3.4.8 Зардлын данс

Төсвийн нийт зарлагыг 1,361,181.1 мянган төгрөгөөр төлөвлөн баталж, гүйцэтгэлээр 1,028,702.8 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 75.6 хувьтай тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын Засаг дарга С.Шижирбаатарын цалинг зөрүүтэй тооцож **236.5** мянган төгрөг илүү олгосон,
- З.Ууганцэцэгт нийгмийн бодлогын мэргэжилтний албан үүргийг хавсран гүйцэтгүүлж, хавсран ажилласны нэмэгдэл цалингаас алба хаасан хугацааны болон зэргийн нэмэгдэл тус тус тооцож нийт **497.7** мянган төгрөг илүү олгосон,
- ИТХ нь албан хаагчдад сургалт хийх зорилгоор Монголын нутгийн удирдлагын холбоонд сургалтын зардал 900.0 мянган төгрөг, Цэлмүүн трейд ХХК-д буудлын хөлсөнд 3,000.0 мянган төгрөг /багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлаас буудлын хөлс шилжүүлсэн/, Шар зам ирээдүй ХХК-д замын үйлчилгээний хөлсөнд 510.0 мянган төгрөг зэрэг нийт **4,410.0** мянган төгрөгийг нэхэмжлэх, сургалтын гэрээ, хөтөлбөр зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,
- Сумын ИТХ-ын ээлжит хуралдааны зардлыг бодит гүйцэтгэлээс **453.5** мянган төгрөгөөр илүү зарцуулсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн "Орон нутгийн төсөвт тодотгол оруулах тухай" 42 дугаар тогтоолоор Сант сум нь тайлант онд 288,442.9 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 293,982.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 101.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Хувь хүний орлогын албан татвар	10,000.0	14,537.0	4,537.0	145.4
2	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар	70,000.0	107,960.7	37,960.7	154.2
3	Хөрөнгийн татвар	8,000.0	11,491.3	3,491.3	143.6

4	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	900.0	663.6	(236.4)	73.7
5	Хадгаламжийн хүүгийн орлого	4,000.0	1,092.0	(2,908.0)	27.3
6	Бууны албан татвар	1,400.0	1,106.0	(294.0)	79.0
7	Малын тоо толгойн албан татвар	133,935.0	57,850.0	(76,085.0)	43.2
8	Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	3,176.5	1,176.5	158.8
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	297.0	297.5	0.5	100.2
10	Газрын төлбөр	10,911.0	6,364.5	(4,546.5)	58.3
11	Дуудлага худалдааны орлого	30,000.0	30,777.4	777.4	102.6
12	Ойн нөөц ашигласны төлбөр	5,663.9	15,632.1	9,968.2	276.0
13	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	90.0	3,192.8	3,102.8	3 дахин
14	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1,246.0	1,118.0	(128.0)	89.7
15	Хүү, торгуулийн орлого	5,000.0	37,685.5	32,685.5	7 дахин
16	Түрээсийн орлого	2,500.0	242.8	(2,257.2)	9.7
17	Бусад орлого	2,500.0	794.6	(1,705.4)	31.8
	Нийт дүн	288,442.9	293,982.3	5,539.4	101.9

Орлогын төлөвлөгөө 5,539.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь хүү, торгуулийн орлого 7 дахин, цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар 1.5 дахин давж биелсэнтэй холбоотой байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давсан орлого

- Хүү, торгуулийн орлого 32,685.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь Сайхан сумын ШШГХ-тэй хамтран ажиллаж, торгуулийн орлогыг суманд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 37,960.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотой байна.

Тасарсан орлого:

- Малын тоо толгойн албан татвар 76,085.0 мянган төгрөгөөр,
- Газрын төлбөрийн татвар 4,546.5 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас төвлөрүүлэх татварыг дутуу төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг 1,016,801.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор:

- Орон нутгийн төсвийн орлогыг 176,554.0 мянган төгрөгөөр,
- Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 642,349.6 мянган төгрөгөөр,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 164,913.6 мянган төгрөгөөр,
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 500.0 мянган төгрөгөөр,
- Урьд оны үлдэгдлээс 49,681.4 мянган төгрөгийг,
- ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 8,695.3 мянган төгрөг,
- ХХС-ын 205,369.6 мянган төгрөг зэрэг эх үүсвэр болон зардлыг 1,248,063.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 55 дугаар тогтоолоор суманд аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 76,993.0 мянган төгрөгөөр бууруулж тодотгосонтой холбоотойгоор сумын ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 42 дугаар тогтоолоор:

- ✓ Орон нутгийн төсвийн орлогыг 288,442.9 мянган төгрөгөөр,
- ✓ Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 565,356.6 мянган төгрөгөөр,
- ✓ Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 164,913.6 мянган төгрөгөөр,
- ✓ Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 500.0 мянган төгрөгөөр,
- ✓ Урьд оны үлдэгдлээс 123,157.9 мянган төгрөгийг,
- ✓ ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 13,440.5 мянган төгрөг,
- ✓ ХХС-ийн 205,369.6 мянган төгрөг зэрэг эх үүсвэр болон зардлыг 1,361,181.1 мянган төгрөгөөр буюу нийт орлого, зарлагыг нэмэгдүүлэн тодотгож баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 20 хөтөлбөрт зориулан 1,361,181.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 825,968.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 334,389.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 200,823.5 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөгдөх зээл, үйл ажиллагааны зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 565,356.6 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, орон нутгийн төсвийн орлогыг 293,982.3 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 500.0 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 164,913.6 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 123,157.9 мянган төгрөгийг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 13,440.5 мянган төгрөг, ХХС-ийн 205,369.6 мянган төгрөгийн зэрэг нийт **1,366,720.5** мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,028,702.8** мянган төгрөг буюу 75.6 хувьтай тайлагнагдсан нь ХХС-аас зээл олгоогүй, ТШЗ-д орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 27,200.2 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 3,771.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 32,242.4 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 7,251.5 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 2,327.4 мянган төгрөгөөр, томилолтын зардал 310.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 964.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 3,030.5 мянган төгрөг, тэтгэмж, урамшуулал 1,167.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 3 төсөл, арга хэмжээнд 22,100.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 17 төсөл, арга хэмжээнд 334,389.1 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 280,999.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 30,901.1 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчдаас 158,765.2 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 1,498.4 мянган төгрөг зэрэг нийт 191,164.7 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Үүнээс цалин хөлсөнд 1,736.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 3,067.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 64,182.5 мянган төгрөг, биет ба биет бус хөрөнгө худалдан авахад 103,360.0 мянган төгрөг зэрэг нийт 172,346.1 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 18,818.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч цаашид /Сант сумын ТТЗ гэх/-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт гүйцэтгэл, нягтлан болох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлт, авлага, өр төлбөртэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үзлээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,440,502.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 24,405.0 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэг зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан нь тус тусын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,762,545.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон **26,438.2** мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сумын ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт № 8 ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Огт мэдээлээгүй
1	Засаг даргын тамгын газар	160	137	23	0
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	160	128	31	1
3	ТТЗ	162	81	77	4
	Нийт дүн	482	346	131	5

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудагд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.4.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.4.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,223.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 13,023.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэн,

102,633.8 мянган төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 86.7 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	5,223.9	1	5,223.9	100.0
Албан шаардлага	6	13,023.8	6	13,023.8	100.0
Зөвлөмж	8	102,633.8	6	30,294.1	75.0
Нийт дүн	15	120,881.5	13	26,918.7	86.7

Өмнөх аудитаар өгсөн бараа материалын худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 457,412.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулж, 59,013.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаанд зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

- ✓ ИТХ нь 140,925.6 мянган төгрөгийн, ЗДТГ нь 302,931.4 мянган төгрөгийн өр төлбөрийн хариуцагчдын нэр, тооцоог зөрүүтэй илэрхийлснээс өр төлбөр дансны дэлгэрэнгүй тайлан үлдэгдлээс 443,857.0 мянган төгрөгөөр зөрсөн,
- ✓ ИТХ-ын 8,178.0 мянган төгрөг болон ЗДТГ-ын 5,377.7 мянган төгрөгийн зэрэг нийт 13,555.7 мянган төгрөгийн багаж, техник, хэрэгсэл худалдан авсан зардлыг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан дансанд тус тус залруулсан.

Залруулагдаагүй алдаа:

- ✓ ЗДТГ нь үндсэн хөрөнгийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 46,116.0 мянган төгрөгийн ахмадын байрны засварын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулсан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, ИББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

боловч дуусаагүй барилга дансанд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "...байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ...хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: 2023 оны эхний хагас жилд багтаан залруулгыг хийж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.

- ✓ ЗДТГ нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 26 нэр төрлийн хөрөнгийн үлдэх өртгийг **12,897.7** мянган төгрөгөөр хасах дүнгээр илэрхийлж, үлдэх өртгийн дүнг бууруулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: 2023 оны эхний хагас жилд багтаан залруулгыг хийж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах.

Аудитаар нийт **163,448.7** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс **734.2** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **25,627.7** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, **137,086.8** мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Сумын Засаг дарга С.Шижирбаатарын цалинг зөрүүтэй тооцож **236.5** мянган төгрөг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.1.2. 3.Ууганцэцэгт нийгмийн бодлогын мэргэжилтний албан үүргийг хавсран гүйцэтгүүлж, хавсран ажилласны нэмэгдэл цалингаас төрийн алба хаасан хугацааны болон зэрэг дэвийн нэмэгдэл тооцож нийт **497.7** мянган төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага:

ИТХ:

1. Төлөөлөгчдөд сургалт хийх зорилгоор Монголын нутгийн удирдлагын холбоонд 900.0 мянган төгрөг, Цэлмүүн трейд ХХК-нд буудлын хөлсөнд 3,000.0 мянган төгрөг /багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлаас буудлын хөлс шилжүүлсэн/, Шар зам ирээдүй ХХК-д замын үйлчилгээний хөлсөнд 510.0 мянган төгрөг зэрэг нийт **4,410.0** мянган төгрөгийг нэхэмжлэх, сургалтын гэрээ, хөтөлбөр зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Ээлжит хуралдааны зардлыг бодит гүйцэтгэлээр тооцоогүйгээс нийт **453.5** мянган төгрөг илүү зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

ЗДТГ:

3. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаж, баталгаажуулаагүйн улмаас бүсийн тэмцээн, уралдааны арга хэмжээнд зориулж сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан шагналын мөнгөнөөс суутгах орлогын албан татварыг зөрүүтэй тооцож **400.0** мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, авлага үүсгэхгүй байх, авлагыг санхүүгийн тайланд бүрэн тусгаж, харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах албан шаардлага хүргүүлэх.

4. Дараах байгууллагууд нийт **2,886.4** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын хавсралтыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ✓ ЗДТГ 2,380.4 мянган төгрөг,
- ✓ ИТХ нь 506.0 мянган төгрөг зэрэг

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

5. Дараах байгууллагууд өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр нийт **17,477.8** мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ✓ ЗДТГ-ын 9,200.0 мянган төгрөг,
- ✓ ИТХ-ын 8,277.8 мянган төгрөг зэрэг.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төсвийн орлогын төлөвлөлт, тодотголтой холбоотой асуудал:

Илрүүлэлт: “2022 оны төсөв батлах тухай” сумын ИТХ-ын 2021 оны 21 дүгээр тогтоолд “Малын тоо толгойн албан татвар”-ыг ногдуулж, төлөвлөөгүйгээс сумын ИТХ-ын 2022 оны 55 дугаар тогтоолоор дээрх орлогыг **133,935.0** мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн төсвийн тодотгол хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “... *төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална.*”, 5.1.2 дахь “*Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан*

байх”, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн орлогыг хууль, эрхийн актад нийцүүлэн иж бүрэн, үнэн зөв төлөвлөж байх.

Цалин, хөлстэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн усны орлогоос цалинжуулсан 2 гэрээт ажилтны **1,355.0** мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгал болон татварын тайланд тайлагнаагүй нь НДШ, ХХОАТ-ын өр төлбөр үүсгэх эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 17.1.1: хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Татвар ногдох орлогод дараах орлого хамаарна” 6.3.1-д “Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид гэрээт ажилчдын цалинг нийгмийн даатгал болон татварын тайланд бүрэн тайлагнаж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаж байх.

Анхан шатны баримттай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Засаг даргын захирамжгүйгээр Засаг даргын нөөц хөрөнгөөс **1,796.8** мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 4.1-д “Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна.”, 5.2-д “Тухайн шатны Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн нэгж шийдвэрийн төсөл болон холбогдох тооцоог хянаж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын захирамжийг үндэслэн нөөц хөрөнгийг зарцуулж байх.

Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: ОНЕО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл, ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй “Гавшгай ус” ААТҮГ-аас авах усны авлага, ХХС-ийн хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн авлага, ИТХ-ын дансанд бүртгэлтэй ажилчдад өгөх өглөг /эзэн холбогдогчгүй, тооцоо нийлсэн актгүй/ зэрэг авлага, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь

өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид авлага, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
ИТХ	2	149,103.6			2	149,103.6	2	149,103.6					
ЗДТГ	3	367,322.8			3	367,322.8	1	308,309.1	2	59,013.7	2	59,013.7	
Дүн	5	516,426.4			5	516,426.4	3	457,412.7	2	59,013.7	2	59,013.7	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин хөлсийг зөрүүтэй тооцож олгосон	2	734.2	2	734.2								
Анхан шатны баримтын бүрдэл дутуугаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан	1	4,410.0			1	4,410.0						
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	2,886.4			1	2,886.4						
Хуралдааны зардлыг бодит гүйцэтгэлээр тооцоогүй	1	453.5			1	453.5						
Авлага үүсгэсэн	1	400.0			1	400.0						

Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан	1	17,477.8			1	17,477.8			
Малын тоо толгойн албан татварыг төлөвлөөгүйн улмаас төсвийн тодотгол хийсэн	1	133,935.0					1	133,935.0	
Гэрээт ажилтны цалинг НД болон ХХОАТ тайланд тайлагнаагүй	1	1,355.0					1	1,355.0	
Засаг даргын захирамжгүйгээр Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулсан	1	1,796.8					1	1,796.8	
Авлага, ер төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй.	1						1		
Дүн	11	163,448.7	2	734.2	5	25,627.7	4	137,086.8	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил				Үүнээс				
	Төлбөрийн акт		Зөвлөмж		Төлбөрийн акт		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Хугацаа хоцроосон	131						131		
Огт мэдээлээгүй	6						6		
Дүн	137						137		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	137						137		